

## БЭЭЖИНГИЙН ОЛИМПИЙН ШИНЭ ӨНГӨ ТӨРХ

XXIX Олимпын наадмыг бид 2008 оны Бээжингийн зуны Олимп гэдгээр нь бид илүүтэй мэдэх билээ. 2001 оны 7 дугаар сарын 13-нд Москва хотод болсон Олон Улсын Олимпийн Хорооны 112-р чуулганаар Торонто, Парис, Стамбул, Осака хотуудыг ардаа орхин Олимп явуулах эзэн хотоор Бээжин хот сонгогдсон билээ. Бээжин хот 2000 оны зуны Олимпийг нутаг дээрээ явуулах саналаа өгсөн боловч 1993 онд энэ боломжийг Австралийн Сидней хотод алдаж байсан билээ.

Эдүгээ дэлхий дахины анхаарал 2008 оны Олимп болох Бээжин хотын зүг хандаад байна. Олимпийн хугацаа ойртох тусам дэлхийн нийтийн энэ анхаарал сонирхол улам бүр өсөн нэмэгдэж байна. Дэлхий дахинд нэр хүндтэй ийм аугаа үйл явдлыг өөрийн оронд зохион байгуулж өнгөрүүлэх болсон нь Хятадын түүхэн дэх томоохон дэвшил болж, энэ үйл хэрэгт Хятадын засгийн газраас ихээхэн ач холбогдол өгч, Олимпийн наадмын бэлтгэл ажлыг далайцтай өрнүүлээд байна. Уг Олимп нь 2008 оны 8 дугаар сарын 8-24-ний хооронд БНХАУ-ын нийслэл Бээжин хотод болж, нээлтийн ажиллагааг 2008 оны 8 дугаар сарын 8-ний 8 цаг 8 минут 8 секундэд эхлүүлэхээр товлосон байна. Энэ нь Хятад үндэстэн наймын тоог эрхэмлэдэг заншилтай холбоотой.

Элсний гар бөмбөг, дарвуулт завь, усан сэлэлтийн 10 км-ийн шинэ буухиа зэрэг төрлүүд далайн эргийн хот Циндао болно. Олон улсын Олимпийн Хороо 2005 оны 7 дугаар сарын 8-нд Хонконгийн Фотан, Шатин дахь спортын институт, морин спортын төрөлд хамтрах болно гэж мэдэгдэв.

Үндэсний Олимпийн хоёр хороо Олимпийн наадмыг удирдан явуулахаар шийдсэн нь Олимпийн түүхэн явц дахь хоёр дахь тохиолдол юм. Үүнтэй төстэй тохиолдол

1956 оны зуны Олимпийн үеэр Австралийн Мельбурн, Шведийн Стокгольм хотуудын хооронд болж байсан.

Хятад улсын Засгийн газар гимнастикийн иж бүрэн 36 заал болон дээд зэрэглэлийн бэлтгэлийн 59 төвтэй цэнгэлдэх хүрээлэнгүүдийг барьж байна.

2008 оны Олимпийн байгууламжууд баригдах талбайгаас 300 000 барилга байшинг нурааж оршин суугчдыг нүүлгэн шилжүүлээд байна. Энд Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэн, үндэсний гимнастикийн ордон, Олимпийн усан парк, Мэдээллийн төв, Олимпийн тосгон, Соёл спортын төв зэрэг архитектурын шилдэг шийдэл бүхий орд харшуудыг босгож байна.

Эдгээр барилга байгууламжуудын тодорхой хэсэг нь Улсын спортын төв захиргааны мэдэлд шилжих ба Олимпийн тоглолтын дараа соёл урлагийн арга хэмжээнд ашиглагдах болно. Олимп Бээжингээс гадна Циндао, Хонконг, Тяньжин, Шанхай, Цинхуандао хотуудад нэг зэрэг болно.

### Спортын төрлүүд

2008 оны Бээжингийн Олимпийн наадам нь спортын төрлүүдийн хувьд 2004 оны Афины Олимпийнхтай адил байна. 2008 оны Олимп нь спортын 28 төрлөөр Афиний Олимпоос 1-ээр илүү буюу 302 тэмцээн уралдаан болно.

Доорх цэнгэлдэх хүрээлэнгүүдэд спортын тэмцээнүүд явагдана. Үүнд:

### Шинэ байгууламжууд:

1. Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэн – хөнгөн атлетик, хөл бөмбөг,
2. Бээжингийн үндэсний усан спортын төв - усан сэлэлт, усанд үсрэлт,
3. Үндэсний битүү дээвэртэй стадион - уран сайхны гимнастик,
4. Бээжингийн буудлагын ордон

5. Сагсан бөмбөгийн битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн,
6. Лаошаны дугуй уралдааны танхим
7. Шунийн завины уралдааны парк,
8. Хятадын ХАА-н их сургуулийн гимнастикийн ордон - бөх,
9. Бээжингийн биеийн тамирын их сургуулийн танхим – ширээний теннис,
10. Бээжингийн ШУТИС-ийн битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн
11. Бээжингийн технологийн их сургуулийн битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн.

**Одоо бэлэн байгаа байгууламжууд:**

1. Олимпийн спортын төв цэнгэлдэх хүрээлэн - хөл бөмбөг,
2. Олимпийн спортын битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн - гандбол,
3. Ажилчны цэнгэлдэх хүрээлэн - хөл бөмбөг,
4. Ажилчны битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн - бокс,
5. Төв битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн - гар бөмбөг,
6. Фенстайгийн бөмбөгийн талбай - хөнгөн
7. Енг тунгийн усан спортын төв - усны бөмбөг,
8. Лаошаны уулын дугуй зам - дугуй, уулын дугуй,
9. Бээжингийн буудлагын төв - буудлага,
10. Бээжингийн технологийн их сургуулийн битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн - гар бөмбөг,
11. Бээжингийн биеийн тамирын их сургуулийн битүү дээвэртэй цэнгэлдэх хүрээлэн - хүндийн өргөлт.

**Түр байгууламжууд:**

1. Олимпийн хурлын төв - хаалтын ажиллагаа, буудлага.
2. Хоккейн талбай - бөмбөгтэй хоккей,
3. Байт харвааны талбай - байт харваа,
4. Газрын теннисийн талбай - газрын теннис,
5. Укэсоны бейсболын талбай - бейсбол,
6. БМС-ийн талбай - тойрог дугуйн уралдаан,
7. Тритлоны байгууламж - тритлон,
8. Дугуйн уралдаан явуулах хотын зам.

**Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэн**

Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэнг 2008 оны Олимпийн наадамд зориулж 2003 оны 12 дугаар сарын 24-өөс барьж эхэлсэн. Засгийн газар энэ ажилд дэлхийн хэмжээний архитектор, дизайнерүүдийн дунд уралдаан зарлаж, Хятадын архитектур дизайн судалгааны групптэй хамтарсан Швейцарын компани түрүүлсэн байна.

Үндэсний цэнгэлдэх хүрээлэнгийн ялгарах онцлог нь дугуй хэлбэртэй араг яс хэлбэрийн бетон бүтцээр хийгдсэн 80000 хүний суудалтай шувууны далавч хэлбэрийн нээж, хаагддаг бүрхүүлтэй том хэмжээний байгууламж юм. 2004 онд дээврийн хэсгийн шийдэл нь аюулгүй байдлын хяналтанд орсон. Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэнгийн талбай том учир Олимпийн нээлт, хаалтын ажиллагаа энд явагдахаар болсон байна.

**Гуандуны цэнгэлдэх хүрээлэн**

Гуандуны цэнгэлдэх хүрээлэн нь Хонконг хотоос 100 миль-ээр хойд чиглэлд Гуанжоу хотод баригдаж 2001 онд БНХАУ-ын үндэсний 8 дугаар их наадмын үеэр нээлтээ хийсэн. Бээжингийн үндэсний цэнгэлдэх хүрээлэн баригдахаас өмнө энэ цэнгэлдэх хүрээлэнд 2008 оны Олимпийн наадмын гол арга хэмжээнүүдийг явуулахаар төлөвлөж байсан. Гуандуны цэнгэлдэх хүрээлэнгийн жинхэнэ дизайн нь 1991 онд 80000 хүний суудалтайгаар хийгдсэн. Гуанжоу хот нь цэцгийн хот гэж нэрлэгддэгийг үндэслэн АНУ-ын архитектурын "Ellerbe Becket" фирм нь Гуандун цэнгэлдэх хүрээлэнг цэцгэн чимэглэлттэй хэвээр байлгахаар шийджээ.

**Бэлэг тэмдэг**

2008 оны зуны Олимпийн бэлэг тэмдгийг "Бүжиглэж байгаа Бээжин"-г болгохоор шийдсэн. Уг бэлэг тэмдэг нь улаан өнгийн дэвсгэр дээр "Бээжин" гэдэг үгэнд ордог "Жин" ханзыг дүрсэлсэн нь Хятадын эртний соёл руу урьж буйг дүрсэлнэ. Олон улсын Олимпийн Хороо анх удаа улаан өнгийн эмблемийг хүлээн зөвшөөрсөн явдал нь Хятад хүний хувьд улаан өнгө нь хамгийн хүндэтгэлийн өнгө байсантай холбоотой.

2008 оны зуны Олимпид зориулан барьж буй барилга байгууламжууд 2007 оны эцсээр бүгд ашиглалтанд орно. Энэ талаар 2006 оны 8 дугаар сарын 6-нд Хэвлэлийн бага хурал дээр 2008 оны Бээжингийн Олимпийг зохион байгуулах хорооны дарга Ван Вэй мэдээлжээ. Эдгээр барилга байгууламжуудын тоонд тэмцээн явагдах 37 байгууламж, бэлтгэлийн зориулалттай 76 барилга байгууламж орно.

Тэмцээний зориулалттай 37 барилга байгууламжаас, 31 нь Бээжин хотод, 6 нь Олимпын уралдаан тэмцээн болох бусад хотод байна. Одоо ашиглагдаж байгаа 9 цэнгэлдэх хүрээлэнд засварын ажил хийгдэж, 2006 оны сүүлчээр нэмж 2 цэнгэлдэх хүрээлэнг засварлаж эхэлсэн. Бээжингийн Олимпийн тасалбарыг хүрэлцээтэй байлгах аар амлаж, зохион байгуулж байна.

2006 оны 11 дүгээр сарын сүүлчээр Бээжингийн Олимпийг зохион байгуулах Хорооноос орох тасалбарын үнийн жагсаалтыг гаргасан. Нийт борлогдох тасалбарын 58 хувь нь 100 юань (12.7 ам доллар)-аас доош үнэтэй байна. Синьхуа агентлагийн мэдээлснээр, хамгийн хямд тасалбар нь 30 юань, хамгийн үнэтэй нь 1000 юань (120 ам доллар) байна гэжээ.

Үүний зэрэгцээ урьдчилсан тоглолтын тасалбар 30-300 юань, тэргүүн байрны медалийн төлөө тоглолтууд 60-1000 юаний

үнэтэй байна. 2008 оны зуны Олимпийн нээлтийн ажиллагааны тасалбарын үнэ 200-5000 юань, хаалтын ажиллагааны тасалбар 150-3000 юань байна. Олимпийн тоглолтын тасалбаруудыг 2007 оны эхний хагас жилээс борлуулж эхэлнэ.

**БНХАУ-ын эрдэмтэд Олимпийн робот хөтөч ашиглахаар зэхэж байна.**

БНХАУ-ын Шинжлэх ухааны академийн эрдэмтэд Бээжингийн зуны Олимпийн ХХІХ наадмын үеэр зочдод үйлчлэх робот хөтөчийг бий болгох төсөл дээр ажиллаж байна гэж “China daily” сонинд төслийн удирдагч Жоу Жиган мэдэгдлээ. Энэхүү робот нь дундаж хүний өндөртэй адил байна.

Энэ робот нь дуу таних функцтэй бөгөөд гар, толгойгоо хөдөлгөх чадвартай болно. Түүний нэрийг “Фува” гэдэг, энэ нь Хятад хэлнээс орчуулбал аз жаргал гэсэн утгатай. Түүнд байрлуулсан фото камер нь зочдод тамирчдын зураг бүхий бэлэг дурсгалыг хийж өгөх зориулалттай. Мөн “Фува” зочдод Олимпийн наадам явагдах цагийн хуваарь байршлалын талаар, Бээжин хотын түүх дурсгалт газрын талаарх мэдээлэл өгөх чадвартай ажээ.

Мэдээллийг бэлтгэсэн ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан Б.Хулан